




Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ

Хүний нөөцийн судалгааг улирал тутам гаргаж, байгууллагын хэмжээнд дутагдалтай байгаа сул ажлын байрны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл байгууллагын сайт [/www.orkhonboet.gov.mn](http://www.orkhonboet.gov.mn) сайтны “Хүний нөөц” цэсний Нээлттэй ажлын байр хэсэгт/, “Мэдээллийн бирж”, ЭМХТ-ийн төв [/https://old.hdc.gov.mn/account.s.php/](https://old.hdc.gov.mn/account.s.php/), Эрүүл мэндийн газар”-ын сайтуудад 42 удаа ил тод нээлттэй тавьж байршуулсны дүнд 2025 оны эхний хагас жилд 19 их эмч 33 сувилагч, тусгай мэргэжилтэн, 8 үйлчлэгч, бусад 9 нийт 69 ажилтныг түр хугацаагаар, хүүхэд асрах чөлөөнөөс 31 ажилтан /11 их эмч, 2 эм зүйч, 16 сувилагч, тусгай мэргэжилтэн, 1 үйлчлэгч, бусад 1 ажилд нь эргүүлэн авсан.




Тайлант хугацаанд байгууллагын хэмжээнд дутагдалтай байгаа болон сул гарсан их эмч, сувилагч, тусгай мэргэжилтний зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл байгууллагын сайт [/www.orkhonboet.gov.mn](http://www.orkhonboet.gov.mn) сайтны “Хүний нөөц” цэсний Нээлттэй ажлын байр хэсэгт/, “Мэдээллийн бирж”, ЭМХТ-ийн төв [/https://old.hdc.gov.mn/account.s.php/](https://old.hdc.gov.mn/account.s.php/), Эрүүл мэндийн газар”-ын сайтуудад нийт 6 удаа ил тод нээлттэй тавьж байршуулсан.Үүнд:/

БОЭТ,Захиралын сонгон шалгаруулалт1 /Эмнэлзүй эрхэлсэн дэд захирал 1 /Төлөвлөлт үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирал/ 1 /Албаны дарга/ 6 их эмч 7, /мэдрэл, гемодиализ, ЧХХ, сэтгэц, өсвөр үеийн/, сувилагч,1 /Тасгийн эрхлэгч 2 / /нягтлан бодогч/ 1 /сүлжээний инженер1/ /Ёс зүйн хороо шинэчлэн байгуулах сонгон шалгаруулах/ бусад /хоол технологич,тогооч,слесарь,хоол зөөгч/ 4 ажилтны зарыг нээлттэй тавьж байршуулсан. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 27.1.4, Төрийн албаны зөвлөлийн гуравдугаар

хавсралт, Авлигын эсрэг хуулийн 6.1.5, Монгол улсын Засгийн газрын “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай” 2017 оны 448 дугаар тогтоолын 2.5 дахь заалтуудыг үндэслэн 2023 оны захиралын “Ажилтан сонгон шалгаруулах журам”-ын (А/29) дагуу сул гарсан 3 ажлын байран дээр 3 удаа сонгон шалгаруулалтыг явуулан (сургалтын албаны дарга, харуул, хоол зөөгч) 3 ажилтныг сонгон шалгаруулалтаар ажилд авсан.

Төрөх, хүүхдийн тасгийн эрхлэгч нар өөрсдийн хүсэлтээр тухайн албанаасаа чөлөөлгөдөх хүсэлт гаргасны дагуу тасгийн эрхлэгч нарын сонгон шалгаруулалтын зар тавьсан боловч нэрээ дэвшүүлсэн материал ирүүлээгүй тул тасгийн ажилчдын хурлын шийдвэрийн дагуу ажлын байранд тавигдах шаардлага хангасан тасгийн өөрийн эмч нарыг /төрөх, хүүхэд, яаралтай тусламжийн тасаг/ тасгийн эрхлэгчид шилжүүлэн томилон ажиллуулж байна.



ЭМЯ, Аймгийн ИТХ, ЗДТГ, ЭМГ -аас ирсэн дээрхи албан бичиг тушаал, дүрэм журам, нийтээрээ дагаж мөрдөх БОЭТ-ийн захиралын тушаал, шийдвэр, дүрэм, журмыг ХНА-ны мэдээлэлийн самбар, БОЭТ-ийн <https://www.orkhonboet.moh.gov.mn> сайтын Хүний нөөцийн албанд ил тод байршуулан тогтмол мэдээлж байна.